

## “БАЯНТЭЭГ” ХК-ИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### 1. УУЛЫН АЖЛЫН ТАЙЛАН:

Баянтээгийн уурхай 2019 онд 400.0 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 150.0 мян.тн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй ажилласан. Хөрс хуулалтанд ЭКГ-5А экскаватор-1ш, HUYNDAI R850LC-9 экскаватор-1ш HUYNDAI R520LC-9S экскаватор-1ш, САМС НМ-390 автосамосвал-2ш, NORD BENZ автосамосвал-4ш, HOWO-60 авто самосвал-2ш, D65E бульдозер-1ш, SD-300N авто ачигч-1ш, Liugong 4180 маркийн автогрейдер зэрэг техникуудээр 1 ээлжээр ажиллаж, хөрс хуулалтыг 52-54, 43-38-р хайгуулын шугам хооронд нийт 600.8 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, нүүрс олборлолтыг 45-54-р хайгуулын шугам хооронд нийт 210.6 мян.тн нүүрс олборлон борлуулж, хөрс хуулалтын төлөвлөгөөг 150.1%, нүүрс борлуулалтын төлөвлөгөөг 140.4%-иар давуулан биелүүллээ. Шилжих нүүрсний нөөц 86.0 мян.тн байна.

### Хөрс хуулалт, нүүрс олборлолт, борлуулалтын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт<sup>1</sup>

1	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	Нүүрс гаргалт	мян.тн	150.0	210.6	140.4%
2	Хөрс хуулалт	мян.м <sup>3</sup>	400.0	600.8	150.1%
3	Нүүрс борлуулалт	мян.төг	4 350 000.0	6 108 370.0	140.4%

### Нүүрс татан авалт аймгуудаар:

Хүснэгт<sup>2</sup>

1	Аймаг	2019 оны гүйцэтгэл /тн/	Борлуулалтанд эзлэх хувь
1	Архангай	25362.15	12
2	Баянхонгор	33544.45	15.9
3	Өвөрхангай	78964.75	37.5
4	Булган	7129.65	3.4
5	Улаанбаатар	24741	11.7
6	Говь-Алтай	6618.9	3.1
7	Дархан	4791.1	2.3
8	Завхан	3817.25	2
9	Төв	5471.1	2.6
10	Сэлэнгэ	1262.45	0.6
11	Хөвсгөл	3574.95	1.7
12	Орхон	11668.2	5.5
13	Ховд	40.4	0.02
14	Дундговь	192.35	0.1
15	Налайх	3454.75	1.6
	<b>Дүн</b>	<b>210633.45</b>	<b>100</b>

## 2. САНХҮҮГИЙН АЖЛЫН ТАЛААР

2019 онд 6363,0 сая.төгрөгийн нийт орлоготой ажиллаж, 3956,1 сая төгрөгийн зардал гарган, 2406,9 сая.төгрөгийн ашигтай ажиллаа. 2019 онд Өвөрхангай, Баянхонгор, Архангай, Булган Дархан, Улаанбаатар, Говь-Алтай, Хөвсгөл, Төв, Эрдэнэт, Завхан, Ховд, Дундговь аймгуудийн байгууллага, иргэдэд нийт 210.6 мян/тн нүүрс олборлон борлуулж, 59 байгууллагатай гэрээ байгуулан нүүрс борлуулсан байна.

2019 онд үндсэндээ 2568,9 сая.төгрөгийн ашигтай ажилласан боловч, нийгмийн хариуцлагын хүрээнд 162,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь зардлыг өсгөж, ашгийг багасгаж харагдуулж байна.

Байгууллагын үйл ажиллагааг өндөр ашигтай ажиллуулахад шинээр санаачлаж хийсэн ажил:

- Ажлын бүтээмж өндөр, зардал бага ЭКГ-5А цахилгаан экскаваторыг сааталгүй ажиллуулах үүднээс ЭКГ 5А-ийн цахилгаан, түүний Якно, 250 трансформатор, карьерийн цахилгаан шугамыг тогтмол хяналтанд байлгаж хэвийн үйл ажиллагааг хангасан.

- Хөрс хуулалтыг оновчтой газар хуулсанаар өндөр мөргөцөг гаргаж, ЭКГ-5А экскаватороор нүүрс ачсанаар цаг хугацаа, зардал, ажлын ачааллыг бууруулж, тээвэрчдэд очерь чирэгдэлгүй үйлчилж, ажилчдын илүү цагийг бууруулж чадсан.

- Ажилчдыг амралтанд амраах, үр дүнгийн урамшуулалыг хагас болон бүтэн жилээр дүгнэж, амралт чөлөөт цагийг зөв зохицуулсан.

- Карьерийн ус татах шуудууг шинээр гаргаж, зүмхийг оновчтой байрлуулсанаас усгүй орчинд үйл ажиллагаа явуулсан.

- Шинэ авто гридерээр замаа түрж, 15м<sup>3</sup>-ын багтаамжтай зам усалгааны автомашинаар замаа тогтмол усалж, чийгтэй элс асгаж ажилласанаар ажиллах нөхцөл сайжирч, цаг хугацаа хэмнэж, дугуй болон нумны эвдрэлгүй ажиллаа.

- Хөрөнгө оруулалтыг цаг хугацааны хувьд оновчтой хийж HUYUNDAI R850LC-9 экскаватор, САМС НМ-390 автосамосвал худалдан авсанаар хөрс хуулалтын төлөвлөгөөг давуулан биелүүлж, олборлолтыг иргэд хөдөлмөрчидөд чирэгдэлгүй ачиж гүйцэтгэлээ.

Товчоор дүгнэхэд 57 жилийн түүхэнд хамгийн их хөрс хуулж, хамгийн их нүүрс борлуулж, хамгийн их ашигтай ажиллаж, хамгийн их техникийн шинэчлэл хийж, анх удаагаа 1.0 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилж, 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр шахмал түлшний үйлдвэр ашиглалтанд оруулсан жил байлаа.

Цаашид анхаарах асуудал:


- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ жил бүр нэмэгдэж байгаатай холбогдож салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2 дахин нэмэгдэж байна. Ж нь: 2018 оны цалингийн сан 650.0 сая төгрөг, 2020 оны цалингийн сан 1200.0 сая төгрөг

- Түлшний үнийн өсөлт хэт их байгаа нь үйл ажиллагааны зардалд нөлөөлж байна. Ж нь: 2017 онд түлшний бөөний үнэ 1400-1500 төгрөг, 2019 онд 1900-2200 төгрөг


- Доллорын ханшны өсөлтэй холбоотой сэлбэг материалын үнэ их өсөж байна.

Иймд бид зах зээлд хамгийн хямдаар зарагдаж байгаа нүүрснийхээ үнийг нэмэх талаар анхаарах нь зүйтэй байна.

## Нүүрс татан авалт аймгуудын эзлэх хувь




### Нүүрсний борлуулалт /мян.тонн/



	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
■ Нүүрсний борлуулалт мян.тонн	47	55.3	68.9	91.4	104.8	111.5	149.3	160	167.4	210.6

### Хөрс хуулалт /мян.м<sup>3</sup>/



	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
■ Хөрс хуулалт мян.м <sup>3</sup>	96.6	80.6	143.6	226.6	251.9	319.8	369.3	489.1	477.6	600.8

“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН 2019 ОНД ТӨЛӨВЛӨСӨН АЖЛЫН ТАЙЛАН

д/д	Техникийн марк	Хийгдэх ажил	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Тайлбар
<b>ТЕХНИКИЙН ИХ ЗАСВАР</b>					
1	ЭКГ-5А	Хүрдний ролик дугуй	15,000.0	7,500.0	Хийгдсэн
		Хүрдний ролик дугуй солих хөлс	10,000.0		Өөрсдөө хийсэн
		Привод барабан	70,000.0	26,300.0	Ноён араа худалдан авсан.
		Цах/ хөдөлгүүр засвар	30,000.0	19,669.6	Цахилгаан хөдөлгүүр засварласан.
		Тулах дугуйн втулка	4,000.0	9,384.0	Худалдан авч сольсон.
		5А бусад үйлчилгээ	10,000.0	13,766.1	Тогтмол хугацаанд үйлчилгээ хийсэн.
2	D-65 бульдозер засвар	Явах анги машмак	40,000.0		Хийгдээгүй
		Тулах гатги	9,200.0	2,529.34	Худ авч сольсон.
3	Терекс 33-05	Хово мотор, кроп	25,000.0	5,000.0	Хроф засварласан.
4	HYUNDAI 520LC-9S	Мотор бүрэн ээлж		60,954.2	Төлөвлөгөөнд тусгагдаагүй мотор бүрэн ээлж хийлгэсэн.
5	Бусад			53,457.26	
<b>ДҮН</b>			<b>213,200.0</b>	<b>198,560.5</b>	
<b>АЖ АХУЙ, ТЕХНИКИЙН УРСГАЛ ЗАСВАР</b>					
	<b>Сэлбэгийн нэр</b>	<b>Техникийн марк</b>			
1	Моторын ээлж	НОРД-№3	5,000.0	938.4	Засвар хийсэн
2	Бүрэн ээлж	HOVA-60	2,500.0	3,655.0	Бүрэн ээлж хийсэн.
3	кроп	HOVA-60	2,500.0	2,845.0	Хроф засварласан.
4	Кран засвар	RHINO 04-71	5,000.0		Хийгдээгүй.
5	Моторын ээлж	TEREX-№1	5,000.0	1,600.0	Кроп засвар
6	Якорь	ЭКГ-5А	3,000.0		
7	Машмак	ЭКГ-5А	10,000.0		
8	Гидрийн шланк ком	HYUNDAI 2900-LC	5,000.0		
9	Бүрэн ээлж	HYUNDAI 2900-LC	5,000.0		
10	Явах насос	HYUNDAI 2900-LC	7,000.0		
11	Аж ахуйн урсгал засвар			39,438.2	
<b>ДҮН</b>			<b>50,000.0</b>	<b>48,476.6</b>	

<b>НИЙГМИЙН ӨМНӨ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА</b>				
<b>1</b>	Баянтээг багийн ЕБС-ийн их засвар	150,000.0	0	<b>Хийгдээгүй</b>
<b>2</b>	Нарийнтээл сумын Халуун ус шинээр барих	80,000.0	80,000.0	Нээлтэй тендер ХААГ зарлаж, Дүүрэн цацрах ХХК шалгарч гүйцэтгэсэн.
<b>3</b>	Баянтээг багийн Хан уул орчимд мал угаалгын ванн барих	15,000.0	0	ХХАА –аар зургийг гаргуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан боловч байгуулах газар тодорхой бус тул сумын ЗД-ын хүсэлтээр хойшлуулсан.
<b>4</b>	Аймаг, сум орон нутгийн нэрийг алдаршуулж байгаа спортын тамирчидад дэмжлэг үзүүлэх	20,000.0	22,941.4	Нарийнтээл сум, Баянтээг ХК-ын нэрийг алдаршуулж байгаа тамирчидад болон аймгийн спортын холбоодод дэмжлэг үзүүлсэн.
<b>5</b>	Нарийнтээл суманд Хөдөлмөрийн баатар, Далай даян Дархан аварга Д.Цэрэнтогтох аваргын хөшөө босгох	60,000.0	59,100.0	Аймгийн ХААГ-аас нээлттэй тендерээр Барималчин Оргилыг шалгаруулж гүйцэтгэсэн.
<b>6</b>	Хот тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн хүрээнд Баянтээг багийн төвд “Ногоон төгөл” байгуулах /хайс/	30,000.0	0	Хот тохижилт ногоон хөгжлийг дэмжих жилийн хүрээнд багийн төвд 1600 м2 талбайг хашаалж, шар хуас эргэн тойрон тариалж, 10 ш гацуур суулган цэцэрлэгт хүрээлэн байгуулаад байна.
<b>7</b>	Баянтээг багийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх	30,000.0	0	Хийгдээгүй
	<b>Дүн</b>	<b>385,000.0</b>	<b>162,041.4</b>	

### **2019 оны нүүрсний чанарын үзүүлэлт**

<b>№</b>	<b>Шинжилсэн үзүүлэлтийн нэр</b>	<b>Чанарын үзүүлэлтүүд</b>
<b>1</b>	Чийглэг $M^{ad}(\%)$	3.0
<b>2</b>	Чийглэг $M_t(\%)$	5.0
<b>3</b>	Үнслэг $A^{dry}(\%)$	12.9
<b>4</b>	Дэгдэмхий бодисын гарц $V^{daf}(\%)$	47.5
<b>5</b>	Нийт хүхэр $S_{tot}^d(\%)$	0.89
<b>6</b>	Илчлэг $Kcal/Q^{ad}$	<b>6626</b>
<b>7</b>	Илчлэг $Kcal/Q^{db}$	<b>6833</b>

## 2019 ХИЙГДСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЙЛАН

д/д	Нэр	Тоо	Улс	Төсөвлөсөн зардал /мян.төг/	Зориулалт	Тайлбар	Гүйцэтгэл ээр сэдвээ /мян.төг/	Тайлбар
1	Экскаватор	1	Солонгос бараа	800,000.0	Хөрс хуулалт, Нүүрс олборлолт	Нээлттэй тендер	800,000.0	“Говь Экуйпмент Рентал Флийт” ХХК 2020 онд 1,089,000.0
2	Өөрөө буулгагч	1	Хятад бараа	660,000.0	Хөрс хуулалт	Нээлттэй тендер	596,000.0	“Нутгийн буян групп” ХХК
3	Автогрейдер	1	Хятад бараа	250,000.0	Зам талбай түрэх	Нээлттэй тендер	248,500.0	“Нисээч интернэшнл” ХХК
4	Шахмал түлшний үйлдвэр	1	ажил	1,000,000.0	Иргэдийн сайн сайханд	Нээлттэй тендер	1,025,880.0	“Баялаг эрдэм цом” ХХК БОАЖЯамнаас 400,000.0 мян.төг
5	Халуун ус засварлах		ажил	20,000.0	Иргэдийн сайн сайханд	Үнийн саналаар худ/авалт	9,800.0	“Эрдэнийн ундрага оргил” ХХК Автогражийн барилгын гадна фасадны засвар
						Үнийн саналаар худ/авалт	9,900.0	“Эрдэнийн ундрага оргил” ХХК Гал тогооны барилгын гадна фасадны засвар
6	Контор засвар		ажил	50,000.0	Ажиллах нөхцөл сайжирна	Үнийн саналаар худ/авалт	49,900.0	Иргэн Г.Чулуунбат гүйцэтгэсэн. Контор, граж, гал тогооны барилгын дээвэр засвар
7	12 айлын орон сууцыг цэвэр бохирт холбох		ажил	50,000.0	Иргэдийн сайн сайханд	Үнийн саналаар худ/авалт	49,500.0	“Дүүрэн цацрах” ХХК 8 айлын сууцны засвар
8	Авто чиргүүл	3	Хятад бараа	110,000.0	Тээвэр	Нээлттэй тендер		Хийгдээгүй.



9	Хайгуулын өрмийн машин	1	Хятад бараа	200,000.0	Нөөц өсгөх	Нээлттэй тендер		Хийгдээгүй.
10	Өвлийн хүлэмж	3	ажил	15,000.0	Ажилчдыг эрүүл хүнсээр хангах	Үнийн саналаар худ/авалт		Хийгдээгүй.
11	Пүүний засвар	1	ажил	15,000.0	Ажиллах нөхцөл сайжирна	Үнийн саналаар худ/авалт		Хийгдээгүй.
12	Мотоцикол	2	хятад				3,700.0	Шууд худалдан авалт
	<b>Дүн</b>			<b>3,170,000.0</b>			<b>2,793,180.0</b>	

### 2019 ОНЫ ТАТВАР, ТӨЛБӨР ХУРААМЖИЙН ТАЙЛАН

д/д	Татвар хураамжууд	1тн нүүрсэнд ногдуулах татвар	Хэмжих нэгж	Төлсөн татвар /мян.төг/	Тайлбар
1.	ААНОАТ		мян.төг	207639.6	
2.	НӨАТ	10%	мян.төг	743100.0	
3.	АМАН татвар	2.5%	мян.төг	139043.1	
4.	Лицензийн төлбөр	581.74га*7250төг	мян.төг	4217.6	
5.	Хайгуулын нөхөн төлбөр	Жилд 10000ам.дол	мян.төг	0	Тухайн үеийн ханшаар
6.	Агаарын бохирдолын татвар	1000	мян.төг	0	
7.	Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого		мян.төг	51551.5	
8.	Хувь хүнээс суутгасан ОАТатвар		мян.төг	103265.9	Ногдол ашиг ба хувь хүнээс
9.	АТӨЯХТатвар		мян.төг	1203.4	
10.	Автын агаарын бохирдол		мян.төг	133.1	
11.	Зам ашигласны төлбөр		мян.төг	415.0	
12.	Газрын төлбөр		мян.төг	3534.7	
13.	Усны төлбөр		мян.төг	1213.4	
14.	ҮХХ-ийн татвар		мян.төг	15758.4	
15.	Хог хаягдалын төлбөр		мян.төг	1182.6	

16.	Бусад төлбөр, хураамж		мян.төг	19359.6	
<b>НИЙТ ДҮН</b>			мян.төг	<b>1291617.9</b>	
17.	Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн хураамж		мян.төг	1200.0	
18.	Даатгалын төлбөр		мян.төг	1788.2	
19.	“Нүүрс ассоциаци” гишүүнчлэлийн хураамж		мян.төг	0	
<b>БУСАД ТӨЛБӨР ХУРААМЖИЙН ДҮН</b>				<b>2988.2</b>	

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018он		2019 он	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.	Үйлдвэрлэлт	мян.тн	130.0	167.4	150.0	210.6
2.	Нийт орлого	мян.төг	3801500.0	5043660.2	4471500.0	6363031.8
3.	Нийт зардал	мян.төг	3123799.3	3025065.2	4186446.8	3956154,1
4.	Ашиг, алдагдал	мян.төг	677700.7	2018595.0	285053.2	2406877.7
<b>1тн нүүрсний өөрийн өртөг</b>		Төгрөг	24029	18060	27909	18782.2
<b>Дараа онд шилжих нөөц</b>		мян.тн	89.5		86.0	

## 2019 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### АВЛАГА, ОР ТӨЛБӨРИЙН ТАЛААР

Үзүүлэлт	2018.12.31 мян/төг	2019.12.31 мян/төг
Авлага	<b>706423.8</b>	<b>740984.3</b>
- Хэрэглэгчидээс	235180.7	439967.0
- Байгууллага хувь хүмүүсээс	471243.1	301017.3
Өглөг	<b>817948.7</b>	<b>1920137.7</b>
- Хэрэглэгчдэд	43726.0	49585.7
- Байгууллага хувь хүмүүсээс	2781.8	1099111.1
- Хайгуулын нөхөн төлбөр	771440.9	771440.9

### 2014-2019 оны санхүүгийн үзүүлэлт сая/төг



	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
■ Борлуулалт	2096.3	2230.9	2986.3	3200.5	4415.7	5552.2
■ Ашиг	463.1	440.8	1024.6	1343.9	2018.6	2406.9
■ Татвар	237.7	356.5	436.9	592.8	713.6	1291.6

### 3. 2019 ОНД ХИЙГДСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

3.1. HYUNDAI R850LC-9 экскаватор - 1ш 1889,0 сая/төг /өглөг 1089,0 сая.төг/



3.2. САМС НМ-390 автосамосвал - 2ш 596.0 сая/төг



**3.3. LiuGong маркийн автогрейдер - 1ш 248.5 сая/төг**



**3.4. Шахмал түлшний үйлдвэр – 1,025.88 сая.төг /Нэмэлт санхүүжилт БОАЖЯ-ны агаарын бохирдолын сангаас 400,0 сая.төгрөгийн дэмжлэг/**





**3.5. Карьер, конторын орчин болон багийн төвийг камержуулав - 10,0 сая/төг**





#### 4. 2019 ОНД ХИЙГДСЭН АЖИЛ:

##### 4.1 Гал тогооны барилгын засвар - 9,9 сая/төгрөг



##### 4.2 Автогражийн барилгын засвар - 9,8 сая/төгрөг





**4.3 Контор, граж, гал тогооны барилгын дээвэр засвар – 49,9 сая/төгрөг**

